



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 08

Мандалговь

Г

Н.Мөнгөнцэцэгийг аймгийн Мэргэжлийн хяналтын
газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын
хэлтсийн даргын албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Норовын Мөнгөнцэцэг 94.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Н.Мөнгөнцэцэгийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын
08-ны өдрийн 08 дугаар тогтоолын хавсралт



**Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол,
хүнсний хяналтын хэлтсийн даргын албан тушаалд
нэр дэвшүүлсэн Н.Мөнгөнцэцгийн тухай дүгнэлт**

1. Н.Мөнгөнцэцг нь 1975 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 47 настай, эмэгтэй
2. Боловсрол: 1993-2000 онд Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийг Хүний их эмч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2000 онд Өндөршил сумын Хүн эмнэлгийн эрхлэгч, 2000-2003 онд Баянжаргалан сумын Хүн эмнэлгийн эрхлэгч, 2003-2006 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвд өрхийн эмч, 200-2011 онд Эрүүл мэндийн газар халдварт судлагч эмч, халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн, хэлтсийн дарга, 2015 оноос Мэргэжлийн хяналтын газар улсын байцаагч, хэлтсийн даргаар ажиллаж байна.
4. Н.Мөнгөнцэцгийн төрийн албаны туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ